



2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ




Шинэ үнэт цаас болон ХК-ийн бүртгэл

2018 оны эхний хагасд Монголын хөрөнгийн биржиг **шинээр үнэт цаас бүртгүүлэхээр 5 компани** хүсэлтээ ирүүлсэнийг судалж, нийт **3 компанийн 809,417,000 ширхэг** үнэт цаасыг шинээр бүртгэж, **13.9 тэрбум төгрөгийг** олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн.



Үнэт цаасны гавхар бүртгэл

Монголын хөрөнгийн зах зээлд үнэт цаасны анхны гавхар бүртгэлийг нэвтрүүлж, Канад улсын **Торонто хөрөнгийн биржиг бүртгэлтэй “Эргэнэ ресурс девелопмент” ХК-ийн 4,000,000 ширхэг** үнэт цаасыг бүртгэж, дотоодын зах зээлээс **2.5 тэрбум төгрөгийг** амжилттай татан төвлөрүүлсэн.



Бүртгэлийн өөрчлөлт

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн биржиг бүртгэлтэй хувьцаагаа хувааж, нэмэлт хувьцаа гаргахаар ирүүлсэн хүсэлтийг судалж, түүний **бүртгэлтэй 113,286 ширхэг үнэт цаасыг 11,328,600 ширхэгт** хуваан шинэчлэн бүртгэхийн зэрэгцээ олон нийтээс **3.7 тэрбум төгрөгийг** татан төвлөрүүлэхээр нэмж гаргасан **4,405,600 ширхэг** үнэт цаасыг нэмж бүртгэсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ



Бүртгэлтэй компанийн нэгдэл

Монголын хөрөнгийн биржиг бүртгэлтэй “Баян-Алгар” ХК болон “Хорго хайрхан” ХК-уудад тус тус **нэгдэхээр 2 компани** хүсэлтээ ирүүлсэнийг судалж, зохих дүгнэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлсэн.



Биржийн гишүүн ҮЦК

2018 оны эхний хагас жилд Монголын хөрөнгийн биржиг шинээр **гишүүнээр элсэхээр 3 компани** хүсэлтээ ирүүлсэнийг судалж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий **“Силвэр лайт секьюритиз ҮЦК” ХХК-ийг МХБ-ийн гишүүнд элсүүлж**, арилжаанд оролцох эрхийг олгосон.



Засгийн газрын үнэт цаас

Тайлант хугацаанд Сангийн яамнаас гомоогын зах зээлд Засгийн газрын үнэт цаас гаргахгүй байх төсөв, санхүүгийн бодлогыг баримталсантай холбоотой биржиг шинээр нэмж ЗГҮЦ-ыг бүртгээгүй буюу анхдагч зах зээлийн арилжаа огт хийгээгүй. Харин **236.9 тэрбум төгрөгийн эргэн төлөлт** хийгдсэн **2,373,052 ширхэг ЗГҮЦ-ыг биржийн бүртгэлээс хассан.**

Журмын шинэчлэлтүүд



Арилжааны журам

Үнэт цаасны арилжааны журамд хаалтын ханшийг илүү бодитой тогтоох зорилгоор сүүлийн нэг цагийн арилжааны жигнэсэн дунджаар ханшийг тогтоохоор тусгасан бөгөөд захиалгын шинэ төрлүүдийг игэвхижүүлэх зэрэг нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан.



Үнэт цаасны бүртгэлийн журам

Үнэт цаасны давхар бүртгэлийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулж, бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын нийтлэг жишиг, практиктэй нийцүүлсэн.



Үнэт цаасны үнийн индекс тооцох журам

ТОП-20 индексийн тооцооллын өөрчлөлт болон шинээр тооцох I ба II ангиллын самбар тус бүрт индексүүдийг тооцоолж эхэлсэн.



НИЙТ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН

IPO,
хоёрдогч
зах зээл

НИЙТ
500

400

300

200

100

ЗГҮЦ
хувьцаа

100

80

60

40

20

2018 оны эхний хагас жилд
ЗГҮЦ-ны анхдагч зах
зээлийн арилжаа огт
хийгдээгүй бөгөөд хоёрдогч
зах зээлийн арилжаа нь
нийт арилжааны 36%.



НИЙТ
98.6
тэрбум төгрөгийн
арилжаа хийв.

ЗГҮЦ-ны арилжаа нь
нийт арилжааны 86.5%

2016 оны эхний
хагас жил

2017 оны эхний
хагас жил


2018 оны эхний
хагас жил

IPO

Хувьцааны хоёрдогч
зах зээлийн арилжаа

ЗГҮЦ-н хоёрдогч
зах зээлийн арилжаа

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



МОНГОЛ  **ШУУДАН**
Чүүцрэгүй хязгаарт өртөөлөл хурган...

BASALTWOOL
МОНГОЛБАЗАЛЫТ ХК

lendmn

ERD
Erdene Resource Development

■ IPO

■ Хоёрдогч зах зээлийн арилжаа

КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

Анхдагч зах зээлийн арилжаа



2017 оны эхний
хагас жил

“Сүү Бонд” нь 2017 оны 06 дугаар сарын 29-ны анхдагч зах зээлээс **6 тэрбум** төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн нь МХБ-ийн түүхэн дэх хамгийн өндөр дунтэй компанийн өрийн хэрэгсэл болсон. 2018 оны 06 дугаар сарын 29-ны өдөр Сүү бондын эргэн төлөлт амжилттай хийгдэж, **бондын хүүнд 1.05 тэрбум төгрөгийг нийт 110 хөрөнгө оруулагчдад төлсөн.**



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР


Хоёрдогч зах зээлийн арилжаа



2018 оны эхний
хагас жил


ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСУУД

ТОП-20



"ТОП-20" ИНДЕКСИЙН САГСЫГ ЖИЛД НЭГ УДАА ШИНЭЧИЛДЭГ БӨГӨӨД 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ӨНГӨРСӨН ОНЫ ҮЗҮҮЛЭЛТЭЭР САГСЫГ ШИНЭЧЛЭХЭД ӨМНӨХ САГСАД БАГТАЖ БАЙСАН 18 КОМПАНИ ХЭВЭЭР ҮЛДЭЖ, "БАТАНУУР", "ЖЕНКО ТУР БЮРО" ХК-ИУД ХАСАГДАЖ, ШИНЭЭР "МИК", "ШИВЭЭ ОВОО" ХК-ИУД НЭМЭГДЭВ.

ЗАХ ЗЭЭЛИЙН ИДЭВХИЖИЛТ



2018 оны 6-р сарын 30-ны өдрийн байгалаар хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээс **“Лэндмн” ХК**-ийн хувьд **16.5 дахин их**, **“Монголбазальт” ХК**-ийн хувьд **3 дахин их**, **“Эрдэнэ ресурс” ХК**-ийн хувьд **1.66 дахин их** давсан үзүүлэлт нь хөрөнгийн зах зээлд сонирхогч болон оролцогчдын тоо нэмэгдэж, зах зээл идэвхижсэнийг харуулж байна.



Erdene Resource Development

АНХНЫ ДАВХАР БҮРТГЭЛ



TSX:ERD


Татан төвлөрүүлсэн хөрөнгө:	
	2,5 тэрбум төгрөг
Бүртгэгдсэн үнэт цаасны тоо ширхэг:	
	3,89 сая ширхэг
Нийтэд санал болгох үнэ:	
	640 төгрөг
МХБ-д гаргасан хувьцааны хувь:	
	2,7%

"Эргэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" нь Канадын Торонто хөрөнгийн биржиг бүртгэлтэй компани бөгөөд Монголын хөрөнгийн биржийн хамгийн анхны давхар бүртгэлтэй компани болсон бөгөөд олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад 1,248 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтгээ 6,478,146 ширхэг худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнг гаруй 66 хувиар давсан үзүүлэлт болсон.





САНХУУГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


МХБ ТӨХК нь 2018 оны эхний хагас жилд үйл ажиллагаанаас нийт 793.7 сая төгрөгийн орлогыг олж, 638.4 сая төгрөгийн зардал гаргаснаар нийт **155.3 сая** төгрөгийн цэвэр орлоготой ажилласан ба MIT цогц системийн ашиглалт, хорогдлын зардлыг хуримтлуулж тооцсоноор санхүүгийн тайланг **103.6 сая** төгрөгийн татварын өмнөх алдагдлыг хүлээн зөвшөөрсөн байна. Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа огт хийгдээгүй болно.




2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ



2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




Лондонгийн хөрөнгийн бирж групптэй байгуулсан Стратеги түншлэлийн "Ажлын мастер гэрээ"-ний хүрээнд МУ-ын Засгийн газрын шийгвэрийн дагуу 2011-2017 онуудад Улсын төсвөөс нийт 21.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд санхүүжилтийн дүнгээр компанийн гурмийн санг нэмэгдүүлэх тухай Сангийн сайдын 2016 оны 334, 2017 оны 114, 2018 оны 68 дугаар тушаалууд тус тус батлагдснаар компанийн гурмийн сангийн хэмжээ **23.1 тэрбум** төгрөгт хүрээг байна.

УЛСЫН ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР

Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь 2018 оны эхний хагас жилд Улсын төсөвт нийт **219.7 сая** төгрөгийн татвар, шимтгэлийг төлсөн.

НИЙТ
219.7
сая төгрөг



2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

■ НДШ

■ НӨАТ

■ ХХОАТ

■ ААНОАТ

■ Бусад татвар,
хураамж